




ОРЧНЫ БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО

Монгол улсын Агаарын бохирдлыг бууруулах бодлого

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны
Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Б.Алтанзул



Улаанбаатар хотын хүн ам өсч, төвлөрөл
нэмэгдсэнтэй холбоотой орчны бохирдол
ихэсч, байгаль орчин болон нийгэм,
эдийн засаг, хүн амын амьдрах орчин,
эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Агаарын бохирдлын эх үүсвэр

80%




ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ
ӨРХҮҮДИЙН
ЯНДАНГИЙН УТАА
БОЛОН АЖ АХУЙН
НЭГЖҮҮДИЙН
ХАЛААЛТЫН ЗУУХНЫ
ЯНДАНГИЙН УТАА

10%



ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН
ЯНДАНГИЙН УТАА

6%






ДУЛААНЫ
ЦАХИЛГААН
СТАНЦЫН
ЯНДАНГИЙН
УТАА

4%



ЗАМЫН ТООС
ШОРОО, ХӨРСНИЙ
БОХИРДОЛ

Агаарын чанарын үзүүлэлт



Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хий болон азотын давхар
ислийн жилийн дундаж агууламж



АГААРЫН БОХИРДОЛ - ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1

Монгол Улсын хууль

- ✓ Агаарын тухай
- ✓ Агаарын бохирдлын төлбөрийн тухай
- ✓ Үндэсний аюулгүй байдлын тухай

2

УИХ-ын тогтоол

- ✓ Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018 оны 2 дугаар тогтоол
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны 24 дүгээр тогтоол

5

ОББҮХ-ны тогтоол

- ✓ Орчны бохирдлыг бууруулахад 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай 2021 оны 21/04 дүгээр тогтоол

3

Засгийн газрын тогтоол

- ✓ Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай 2017 оны 98 дугаар тогтоол
- ✓ Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх журмыг батлах тухай 2017 оны 199 дүгээр тогтоол
- ✓ Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай 2018 оны 62 дугаар тогтоол
- ✓ Журамд өөрчлөлт оруулах тухай 2020 оны 115 дугаар тогтоол
- ✓ Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай 2020 оны 200 дугаар тогтоол

4

Сайдын тушаал

- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2017 оны А/107 дугаар тушаал
- ✓ Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам батлах тухай 2020 оны А/604, А/1112 дугаар хамтарсан тушаал, захирамж



АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт:

01

- ✓ Хүрээлэн байгаа агаарыг хамгаалах
- ✓ Бохирдохоос урьдчилан сэргийлэх
- ✓ Агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавих

Хамрах хүрээ:

02

- ✓ Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг бууруулах
- ✓ Озоны үе давхаргыг хамгаалах
- ✓ Агаарын бохирдлыг бууруулах

Байгаль орчны асуусдал эрхэлсэн ТЗТБ-ын бүрэн эрх:

03

- ✓ Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- ✓ Агаарын талаарх мэдээллийн сан бүрдүүлж, хяналт тавих
- ✓ ОЗБ болон бусад орлуулах бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах
- ✓ Агаар бохирдуулах томоохон суурин эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл олгох
- ✓ Мэргэжлийн албаны дүгнэлт гаргуулах үйлчилгээний тарифыг тогтоох
- ✓ Аюултай бохирдуулах бодисын жагсаалтыг батлах



АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт:

Агаар бохирдуулагч этгээдэд агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төлбөрийн хувь хэмжээ:




Экспортлосон
нүүрс кг тутамд
1-2 төг



Органик уусгагчийн
килограмм тутамд
10-30 төг



1800-9500
төг



Агаарт гаргах
бодис, кг тутамд
1-10 төгрөгийн

Төлбөр төлөгчид:

- түүхий нүүрс олборлогч;
- органик уусгагч импортлогч;
- автотээврийн хэрэгсэл эзэмшигч;
- агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигч;
- агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.



ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ



ҮАБЗ-өөс 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 52/30 дугаартай “Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай” зөвлөмжийг гаргасан.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн бүрэлдэхүүн хэсэгт:

3.4.9. Экологийн аюулгүй байдал.



УИХ-ЫН ТОГТООЛ

Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018 оны 2 дугаар тогтоол

- ✓ Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан нэн даруй авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны 24 дүгээр тогтоол

- ✓ 5.1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- ✓ 5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ



2017

98 дугаар тогтоол

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөр 2 үе шаттай.

- Нэгдүгээр үе шат: 2017-2019
- Хоёрдугаар үе шат: 2020-2025



2017

199 дүгээр тогтоол

Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх журмыг баталсан.



2018

43 дугаар тогтоол

Мэргэжлийн хяналтын газрын бүтцэд агаарын чанарт хяналт тавих үүрэг бүхий нэгжийг шинээр байгуулсан.



2018

62 дугаар тогтоол

2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон.





2020

35 дугаар тогтоол

Улаанбаатар хотын
зүүн бүсэд
сайжруулсан шахмал
түлшний үйлдвэр
барьж ашиглалтад
оруулах тухай
шийдвэр гарсан.



2020

115 дугаар тогтоол

2018 оны 62 дугаар
тогтоолд өөрчлөлт оруулж
ХУД-ийн 12,13,14, СХД-ийн
21, БЗД-ийн 20 дугаар
хороонд түүхий нүүрс
хэрэглэхийг хориглосон;



2020

189 дүгээр тогтоол

“Гэр хорооллын айл
өрхөд цахилгаан эрчим
хүчний тарифын
хөнгөлөлт үзүүлэх
журам”-ын 2.2 дахь
заалтын “50 хувиар”
гэснийг “100 хувиар”
гэж өөрчлөн баталсан.




2020

200 дугаар тогтоол

Коронавируст халдвар
(КОВИД-19)-ын цар тахлын
улмаас Гамшгаас хамгаалах
бэлэн байдлын зэрэгт
шилжсэнтэй холбогдуулан
нийслэлийн гэр хорооллын
иргэдэд дэмжлэг үзүүлэх
зорилгоор сайжруулсан
шахмал түлшний нэг тонн
тутмын үнийг 75 хувиар
хөнгөлөх арга хэмжээг авсан.



САЙДЫН ТУШААЛ



- ✓ 2020 оны А/604, А/1112 дугаар хамтарсан тушаал, захирамжаар Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчилсэн.
 - ✓ Төвийн 6 дүүргийн алслагдсан 5 хороог бүсэд шинээр нэмсэн.
 - ✓ Уур үйлдвэрлэгч ААНБ-ыг сайжруулсан түлшний үндсэн түүхий эд болох мидлинг түр хэрэглүүлэх зохицуулалт шинээр нэмсэн.

- ✓ Шадар сайдын 2020 оны тушаалаар 2021 оноос уур үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд, 2023 оноос эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй усан халаалтын зуухнуудад түүхий болон баяжуулсан нүүрс хэрэглэхийг тус тус хориглосон.





ОРЧНЫ БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 43 дугаар зарлигаар
“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо” анх
байгуулагдсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 151 дүгээр захирамжаар
Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн, ажиллах журмыг
баталсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 247 дугаар захирамжаар
Үндэсний хорооны бүрэлдэхүүн болон ажиллах журмыг шинэчлэн
баталсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 51 дүгээр захирамжаар
Үндэсний хороог Ерөнхий сайдаар ахлуулан шинэчлэн байгуулж, дэд
даргаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд томилогдов.

Ерөнхий сайдын 2018 оны 116 дугаар захирамжаар Үндэсний
хорооны нарийн бичгийн дарга нь Ажлын албаны даргаар
ажиллахаар томилогдсон.

Ерөнхий сайдын 2018 оны 160 дугаар захирамжаар Байгаль орчин,
аялал жуулчлалын сайд Үндэсний хорооны дарга байхаар зохион
байгуулсан.



Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2018 оны 18/04 дүгээр тогтоолоор зарим гишүүдийг шинэчилж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Амьдрах орчин, ногоон хөгжлийн бодлогын зөвлөх, Цагдаагийн Ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Брийт Монголиа ТББ зэрэг байгууллагын дарга, төлөөллүүд болон НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч нь ажиглагч статусаар тус тус ажиллаж эхэлсэн.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны 19/04 дүгээр тогтоолоор Үндэсний хорооны ажиллах журмыг шинэчлэн баталсан.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2020 оны “Үндэсний хорооны бүрэлдэхүүн шинэчлэх тухай” 20/03 дугаар тогтоолоор бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоож дарга, болон гишүүд нийт 31 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа өргөжүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2021 оны 21/01 дүгээр тогтоолоор Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн 12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байхаар баталсан.

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

- ✓ Үндэсний хорооны 21/04 дүгээр тогтоолоор 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

01

Ерөнхий төлөвлөгөө

Агаар, орчны бохирдлыг бууруулахад хэрэгжүүлэхэд чиглэсэн 27 ажил

02

Он дамнан хэрэгжих

Цар тахалын үеийн нөхцөл байдлаас шалтгаалан он дамнан хэрэгжиж буй 42 гэрээт ажил

03

ОУ-ын байгууллага

Олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх 10 ажил

04

Эрх зүйн орчин

БОАЖЯ, УУХҮЯ-тай хамтран эрх зүйн орчин бүрдүүлэхэд чиглэсэн 10 ажил



Агаарын бохирдлыг бууруулахад 2021 онд хэрэгжүүлэх ажлууд

✓ Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

4.2.4

Гэр хорооллын айл өрхөд шөнийн цахилгааны үнийн хөнгөлөлт олгох

4.1.9

Нам даралтын зуухыг эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, хийн зуух, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр солих

4.2.7

Аймгуудын нам даралтын болон дулааны станцын зуухны янданд утаа шүүгч суурилуулах

4.2.17

Ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлж, зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас олгох

4.2.3

4.5.3

4.5.7

Шаардлага хангасан сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, нөөцлөлт, тээвэрлэлт, хяналтад дэмжлэг үзүүлэх

4.3

Нийтийн болон авто тээврийн утааг багасгах арга хэмжээ авах зорилгоор дэвшилтэд техник, технологийг туршин нэвтрүүлэх

4.5.9

Нийслэл, орон нутагт агаарын чанарыг хянах 2 иж бүрэн автомат ажиллагаатай станцыг байгуулах, хяналт-шинжилгээний сүлжээг бэхжүүлэх

5.1.5

Нийслэлийн хэмжээнд ногоон мод тарих

4.5.9

4.2.17

ОУ-ын байгууллагуудтай хамтарсан төсөл хөтөлбөрүүд



Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд:



БОАЖЯ, УУХҮЯ, ЭХЯ, АНЗДТГ, ЗТХЯ, Таван толгой түлш ХХК, Төрийн банк, Хаан банк, Хас банк



НҮБ-ийн Хүүхдийн сан / UNICEF



АНУ-ын Элчин сайдын яам, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг / USAID



Жайка-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар / JICA





ОРЧНЫ БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО

Анхаарал хандуулсанд баярлалаа.

